БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 19 өдөр Дугаар А/296 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.3, 20 дугаар зүйлийн 20.1.4, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хороодын 2026 оны улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, нууц материалыг хадгалах, хамгаалах, хүргүүлэхэд шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээлэл, аюулгүй байдлыг чанд сахин ажиллахыг Цэргийн штаб (Г.Нямхүү)-т үүрэг болгосугай

3.Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагууд дайчилгааны даалгаврыг үндэслэн дайчилгааны төлөвлөгөө боловсруулан ажиллахыг дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

4.Дайчилгааны төлөвлөгөөний төслийг боловсруулан нийслэлийн Засаг даргаар батлуулах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т даалгасугай.

5.Дайчилгааны төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах 858,480 (найман зуун тавин найман мянга дөрвөн зуун ная) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж 1266100644

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дүгээр сарын 09-ны өдрийн
А/222 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:
Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга
Боловсролын хэлтсийн дарга
Татварын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
91 дүгээр сургуулийн захирал
94 дүгээр сургуулийн захирал
Багахангайн тохижилт ОНӨААТҮГ-ийн захирал
Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ийн захирал
Теле камерын хяналтын дэд төв ОНӨААТҮГ-ийн захирал, Илч-Орд ОНӨААТҮГ-ийн захирал
Илч-Орд ОНӨААТҮГ-ийн захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
Налайх эрчим хүчний салбарын Өндөртолгой хэсгийн мастер
Статистикийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, улсын дайчилгааны асуудал хариуцсан ажилтан

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугээр сарын 19-ны өдрийн
А/886 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.Нууцын бичиг хэргийн зардал					
1	Цаас устгагч /16л/	ширхэг	1	600,000	600,000
2	Шатахуун	л	72	3590	258,480
	Дүн				**858,480**